“48ЦКН” – ын кино хийх тухай албан ёсны журам

Доорх журам баг, киноны уран бүтээлч тус бүрт үйлчлэх ёстой.

А. Цаг хугацаа

- “48 цаг кино наадам” (48ЦКН) нь тухайн улс, хотын байдлаас хамааран бүтэн жилийн турш өөр, өөр амралтын өдрүүдэд дэлхий даяар зохиогдож эхэлдэг.
- “48 цаг кино наадам” нь тухайн болж буй улс, хотын цагаар Баасан гарагийн оройн 7 цагт эхэлж, Ням гарагийн оройн 7 цагт дуусна. Энэ нь "48ЦКН” –ын албан ёсны цагийн хуваарь юм. (Наадам зохиогдох амралтын өдрүүд нь тухайн улс, хотоос хамааран өөр байж болно.)
- Оролцогч багууд бүрэн хийж дуусгасан хальсны кино, видеогоо заасан газарт нь, тогтсон цагт буюу Ням гарагийн оройн 7 цагаас хоцрохгүйгээр хүргэж өгөх ёстой.
- Эдгээр заалтын дагуу зөвхөн цагтаа ирсэн бүтээлүүд шалгаруулалтанд орох эрхтэй болно. Ням гарагийн оройн 7 цагаас өмнө (хоцролгүй ирүүлсэн, мөн хоцорсон) эсэхээс үл хамааран бүх бүтээлийг кино театрт үзүүлнэ.

В. Бүх бүтээл "48ЦКН”–ын албан ёсны цагийн хуваарийн дагуу хийгдсэн байх ёстой. Баримтлах ёстой хуваариас өмнө хийгдсэн кино, видеог ашиглахыг хатуу хориглоно. Хуваарийн дагуу хийх ажил:

- Кино зохиол бичих
- Сургуулилт хийх
- Хувцас, тайз чимэглэл хийх
- Зураг авалт
- Эвлүүлэг
- Дууны эвлүүлэг
- Rendering буюу уншуулах
- Outputting буюу бүтээлээ гаргах зэрэг орно.

С. 48ЦКН” – ын албан ёсны цагийн хуваариас өмнө хийж болох зүйлс:

- Багаа бүрдүүлэх
- Жүжигчдээ сонгох
- Техник, тоног төхөөрөмжөө бэлтгэх
- Зураг авах газраа сонгон, заагдсан зөвшөөрлийг авсан байх.

(Мөн журмын “D” болон “I “ заалтыг харна уу)

D. Бүтээлд орох бүх дүрсийг 48 цагийн дотор авсан байх ёстой.

- Урьд нь авсан дүрс, бүтээсэн бүтээлүүд, мөн архивын бичлэг ашиглахыг үл зөвшөөрнө.
- Animation, Special Effects хэрэглэхийг зөвшөөрөх боловч заавал эхнээсээ л 48 цагийн дотор бүтээсэн байх ёстой. (Тэмдэглэл: Архивын бичлэг нь special effects-ний програмны effect дотор байвал хэрэглэхийг зөвшөөрнө.)
- Фото зураг ашиглахыг зөвшөөрнө, Гэхдээ оролцогч багууд тухайн фото зургийг ашиглах зохиогчийн эрхтэй байх ёстой. Фото зургийг заавал 48 цагийн дотор авсан байх шаардлагагүй.

E. Оролцогч багууд өөрийн ахлагч, эсвэл төлөөлөгчийг “48 цаг кино наадам” эхлэх үйл ажиллагаанд оролцуулах ёстой.

- Эхлэх үйл ажиллагааны үеэр баг бүр ахлагчийнхаа гарын үсэгтэй "Багийн ахлагчдийн гэрээ" - г авчирч өгөх ёстой. (Энэхүү гэрээг "48 цаг кино наадам" – ын вэб хуудаснаас татаж авч болно) Гэрээ өгөөгүй багууд уралдаанд орох эрхгүй болно.
- Баг бүр хийх киноныхоо төрөл зүйлийг сугалаагаар сонгох болно.
- Баг тус бүр анх сонгосон төрөл зүйлээ нэг удаа солих эрхтэй. Хэрэв нэг удаа сольсон бол анх сугалсан төрөл зүйлээ эргүүлэн авах эрхгүй.

F. Оролцогч баг тус бүр төрөл зүйл, баатар, зайлшгүй хэрэглэгдэх зүйлс (Prop), мөн зайлшгүй хэрэглэгдэх ёстой өгүүлбэр зэргийг бүтээж буй кинондоо заавал оруулсан байх ёстой.

- Зайлшгүй хэрэглэгдэх ёстой зүйлс, баатар нь дэлгэц дээр харагдах ёстой.
- Хэрэглэх ёстой өгүүлбэрийг зайлшгүй ашиглана. Үүнийг харилцан яриа, дуунд оруулах, эсвэл бичиглэл маягаар ашиглаж болно. Өгүүлбэр ямар ч хэл дээр байж болох боловч, тухайн үг, өгүүлбэр нь ойлгомжгүй гэж үзвэл англи субтитр хийх шаардлагатай.
- *“48 цаг кино наадам”-д орох эрх олж авахын тулд баг тус бүр киногоо сонгосон төрөл зүйлээр, өгөгдсөн бүх баатрыг ашиглан зайлшгүй хэрэглэгдэх ёстой зуйлс (Prop), мөн хэрэглэгдэх ёстой үг, өгүүлбэрүүдийг оруулан бүтээх ёстой. Үүнээс гадна бүтээл заагдсан хугацаанд хийгдсэн байх ёстой.*

G. Оролцогч бүх уран бүтээлч, жүжигчид сайн дурын үндсэн дээр, өөрөөр хэлбэл үнэ хөлсгүй ажиллах ёстой.

H. Видео, мөн хальсны бүх төрлийн техник төхөөрөмжийг ашиглаж болно. Хэдэн ч камер хэрэглэж болно.

I. Зөвхөн “Анх удаа зохиогдож буй хот” гэсэн журам үйлчилнэ: Тухайн улс, хотыг таних зорилгоор, хийгдсэн бүтээл бүхэнд, байшин барилга, хөшөө дурсгал, чимэглэл, байгалын гоё сайхан гэх мэт тухайн улс, хотын таних тэмдгийг оруулсан байх шаардлагатай. Энэ заалт зөвхөн “48 цаг кино наадам-ыг анх удаагаа зохион байгуулж буй хот, улс орнуудад хамаарана.

J. Киноныхоо хөгжмийг хийхдээ өөрийн улс, хотын хөгжмийн зохиолч, хөгжимчидтэй хамтран ажиллахыг оролцогч багуудад зөвлөж байна. Оролцогч багууд урьд өмнө нь зохиогдсон, бичигдсэн дуу, хөгжмийг кинондоо ашиглаж болох боловч тэдгээр бүтээлийн зохиогчийн эрхийг авсан байх шаардлагатай. Бүтээлд ашиглагдсан дуу, хөгжмийн зохиогчийн эрхийг авсан баримтыг хавсаргах ёстой. Урьд өмнө нь бүтээсэн, хураасан Sound Effect - үүдийг мөн адил зохиогчийн эрхтэйгээр л ашиглаж болно. Өмнө нь зохиогдсон, бичигдсэн дуу, хөгжмийн үг, аяыг өөрчлөн хэрэглэж болох хэдий ч мөн л эх бүтээлийнх нь зохиогчийн эрхийг хавсаргах шаардлагатай. Энэхүү журам нь АНУ, олон улсын зохиогчийн эрхийн хуулийн "Fair Use" заалтаас үл хамааран үйлчлэх ёстой.

K. Бэлэн болсон бүтээл доод тал нь 4 минут, дээд тал нь 7 минутын хэмжээтэй байх ёстой. Үүнд бүтээлийн төгсгөлд гарах уран бүтээлчдийн нэрс орохгүй.(Журмын “L” заалтыг харна уу)

L. Төгсгөлд гарах уран бүтээлчдийн нэрс (End Credit) нь 60 секунд байх ёстой. “K” заалтад дурдсан, бүтээлийн байж болох хугацаан дээр энэ 60 секунд нэмэгдэх юм. (Энэ нь хэрэв таны кино яг 7 минут бол дээр нь 60 секунд буюу нэг минут нэмэгдэн, нийт 8 минут болно гэсэн үг.)

Төгсгөлд гарах уран бүтээлчдийн нэрс дараах үгийг заавал оруулсан байна. "This film was made for the 48 Hour Film Project. www.48hourfilm.com"

Эхэнд гарах уран бүтээлчдийн нэрсийг киноны нэг хэсэг гэж үздэг учир 7 минутын үргэлжлэх хугацаанд багтана. Нэмж хэлэхэд хэрэв таны кинонд эхэнд гарах уран бүтээлчдий нэрс байгаа бол дараах өгүүлбэрийг зайлшгүй оруулсан байх ёстой:

- "<танай багийн нэр> гараад дараа нь presents эсхүл үзүүлж байна". Дараа нь "a 48 Hour Film Project" зайлшгүй гарах ёстой, эсхүл
- the text "a 48 Hour Film Project" гэсэн үг киноны нэр гарсаны дараа зайлшгүй байх ёстой.

"a 48 Hour Film Project" гэсэн үг хашилтан дотор байж болохгүй, бүх үгийг жижиг үсгээр бичсэн байж болно. (Жишээ нь: "a 48 hour film project").

M. Америк, Канад, Чили, Япон, Перу, Өмнөд Солонгос, Тайван зэрэг оронд хийж дууссан бүтээл NTSC систем дээр байх ёстой. Харин бусад орны хувьд PAL систем дээр хийгдсэн байна.

Хэрэв тухайн хот, улсын “48ЦКН” – ын зааварт ямар системээр хийхийг заагаагүй бол энэ журам бүрэн үйлчилнэ. Таны бүтээл дараахь форматын (Format) дагуу хийгдсэн байх ёстой:

- Бие даасан HD кино, Quicktime файл байх ёстой.
  - DVD дээр дата файлээр байж болно
  - USB flash буюу флайш дээр байж болно..

Өөрийнхөө хотын цахим хуудаснаас киногоо ямар форматаар хүлээлгэж өгөх ёстойг шалгаарай. Хэрэв таны кино танай хотын киноны форматны шаардлагыг хангахгүй бол шалгаруулалтаас хасагдах магадлалтай. Мөн таны бүтээлийг "48ЦКН" – ын техник хэрэгсэл дээр тоглуулах боломжгүй бол та шалгаруулалтанд орох эрхгүй болно.

N. Бүтээлээ хүлээлгэж өгөх талаар:

Цаг хугацаандаа, мөн цагаасаа хоцорсон бүх бүтээлийг кино театрт журам R- ийн дагуу гаргана. Та бүтээлээ үзэгчдэд чанартай хүргэе гэвэл дараахь зүйлийг анхаарна уу:

- Бид бүх багуудад дууссан бүтээлээ 2 хувь өгөхийг зөвлөж байна.
- Дуу, хөгжмийн түвшин бүтээлийн турш нэгэн жигд байвал сайн. (Хэрэв бүтээлийн тань дуу, өндөр нам байвал кино театрын төхөөрөмжийг хамгаалах үүднээс намуухан тоглуулна.)
- Кино театр бүрийн тоглуулагч прожектор өөр өөр тул бүтээлийнхээ ерөнхий өнгийг анзаараарай. Зарим театрт кино дэлгэц дээр хэтэрхий харанхуй, бараан харагдах тохиолдол байдаг.
- Дүрэм R-д зааснаар цагтаа ирсэн болон хоцорсон кинонуудыг бүгдийг нь кино театрт гаргах болно.

O. Дуусгасан бүтээлийн эхэнд дараахь зүйлс орсон байх шаардлагатай:

- Таван (5) секундын харанхуйлал
- Title Card буюу Нэрийн карт. Үүнд: Багийн нэр, огноо, улс, эсвэл хот, киноны нэр, төрөл зүйл
- Энэ animation

  Эсхүл

  Дараах үгийг бичсэн Title Card буюу Нэрийн карт: "This film was made for the 48 Hour Film Project 2013. www.48hourfilm.com"

  Энэхүү киног "48 цаг кино наадам"-д зориулан бүтээв"

- Хоёр (2) секундын харанхуйлал
- Тэгээд таны кино эхлэх ёстой.

P. Бүх баг, түүний гишүүд, жүжигчин, зураг авсан газар, хэрэглэсэн дуу, хөгжмийнхөө зохих зөвшөөрлийн бичгийг, бүрэн бэлэн болсон бүтээлийн хамт тухайн хот, улсын зохион байгуулагчдад хүлээлгэн өгсөн байх хэрэгтэй. ("48

ЦКН”-ын сайтаас зохих зөвшөөрлийн хуудсыг татаж авч болно) Зөвшөөрлийн бичиг баримт дутуу бол “48 цаг кино наадам”-ын зохион байгуулагчид тухайн бүтээлийг шалгаруулалтаас хасах бүрэн эрхтэй.

Q. Оролцогч бүх баг, “48ЦКН”- ын албан ёсны журмыг чандлан мөрдөхөө амалсан (Батламжийн мэдэгдлийг) бөглөж өгсөн байх шаардлагатай.

R. “48 цаг кино наадам”-д оролцох эрх авахын тулд, оролцох сонирхолтой баг, түүний гишүүд нь өөр бусад уран бүтээлчийн зохиогчийн эрхийг зөрчихгүй байх ёстой. Хийж буй бүтээл нь үзэгчдийн сэтгэлд нийцэхүйц байхаас гадна өөрсдөө хийсэн байх ёстой. (Бусдыг хэт доромжилсон, гутаасан зүйл байхыг хориглоно.) Мөн порно чиглэлийн зураг, ёс зүйд үл нийцэх, хувь хүн, албан байгууллага, жирийн иргэдийн нэр төрийг гутаасан, тэдний эрх чөлөөнд халдсан, хууль тогтоомжид харшилсан, зохиогчийнн эрхийг зөрчсөн (Үүнд “48ЦКН” - д оролцогчдын өөрсдийн бүтээл үл хамаарна) зүйлс оруулахыг хатуу хориглоно.

“48ЦКН” - ын журам, заавар, дүрмийг зөрчсөн, ёс зүйд үл нийцэхүйц утга санаа агуулсан бүтээлийн шалгаруулалтад орох эрхийг хасна. “48ЦКН” нь хэнийг оролцуулахаа дотроо шийдэх бүрэн эрхтэй. “48ЦКН” нь мөн киног театрт гаргахгүй болон киноны үзлэгийн үеэр киноны агуулгын талаар мэдээлэхгүй байх эрхтэй.

S. Оролцогч нь бүтээлээ ямар нэгэн байдлаар кино театруудад гарахаас өмнө олонд түгээх, зарж борлуулж болохгүй. Үүнд интернет дээр киногоо тавих мөн орно. Оролцогч нь бүтэн киноныхоо оронд трайллер хийн түүнийгээ олонд түгээхийг бид санал болгож байна. Энэхүү трайллер нь 48 секундээс хэтэрч болохгүй.

T. “48 цаг кино наадам”-д албан ёсоор оролцох эрх олж авахын тулд баг, түүний гишүүдийн бүтээл нь бүхий л журам, зааврын дагуу хийгдсэн байх ёстой. “48 цаг кино наадам” нь зөвхөн “48ЦКН”-ын “албан ёсоор оролцох эрхтэй” гэж үзсэн бүтээлийг л шалгаруулалтад орохыг зөвшөөрөх бүрэн эрхтэй.

U. Хүлээлгэн өгсөн бүх бүтээл, бичиг баримтуудыг буцааж олгохгүй.

V. “48 цаг кино наадам”, түүний гишүүд зүйд нийцээгүй, зохимжгүй, шаардлага хангаагүй бүтээлүүдийг хасах бүрэн эрхтэй.

W. "48ЦКН” –ын бүх шаардлагыг хангаж, албан ёсоор оролцох эрх авсан бүтээлүүд нь тухайн болж буй хот, улсынхаа "48 цаг кино наадмын шилдэг кино" шагналын төлөө өрсөлдөх эрхтэй.

X. Тухайн хот, улсынхаа "Шилдэг кино" - гоор шалгарсан бүх бүтээл "2013 оны Шилдэг 48 Цаг Кино" шагналын төлөө өрсөлдөх эрхтэй. Мэргэжлийн шүүгчид шагналын эзнийг тодорхойлох болно.

Y. “48 цаг кино наадам”-ын зохион байгуулагчид тэмцээн эхлэхийн өмнө дээрх журамд нэмэлт оруулах, мөн өөрчлөлт хийх бүрэн эрхтэй.

48 цагийн дотор кино бүтээхэд секунд бүр үнэтэй!